



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/502

Мандалговь

Барилга байгууламжийг ашиглалтад  
оруулах комисс ажиллуулах тухай

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн мооргийн барилгын засварын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Н.Эрдэнэ-Очир	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга:	Г.Бат-Орших	(Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга)
Гишүүд:	Н.Эрдэнэбат	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)
	А.Бямбаа	("Мандал харш" ХХК-ний инженер)
	А.Батхуяг	("Хайя тек" ХХК-ийн захирал)
	Х.Жаргал	(Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга)
	П.Алтанчимэг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)

Хоёр. Засварын ажлыг хууль, дүрмийн дагуу ажиллаж, зураг, төслийн дагуу гүйцэтгэсэн байдалд дүгнэлт гарган, архивт хүлээлгэн өгч мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхийг комисс (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж.МӨНХЧУЛУУН

488010538